



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 16 өдөр

Дугаар А/176

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.4, 4.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 04 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2024 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн 11 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хилийн цэргийн 0257 дугаар ангийн хүсэлтийг шийдвэрлэх зорилгоор Хил хамгаалах байгууллагын 90 жилийн ой, хилчдийн нийгмийн хамгаалал хөтөлбөрийн хүрээнд тус ангийн цэргийн гал тогооны засварын зардалд 15,000,000 (арван таван сая) төгрөгийг зарцуулсугай.

2.Дээрх зардлын 15,000,000 (арван таван сая) төгрөгийг аймгийн Засаг дарга дансны “Иргэд, байгууллагаас ирүүлсэн санал хүсэлтийг шийдвэрлэх зардал”-аас гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Батбилгүүн)-д зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (Р.Машбат)-д даалгасугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ